



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөгжил хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2023/12/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Өмнөговь аймаг
2023 он

Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал:
Ч.Баярсайхан
Утас: 89000060 Цахим хаяг: bayaraach85@gmail.com

Аудитын менежер: Г.Ганцэцэг
Утас: 88883775 Цахим хаяг: jni.gantsetseg@gmail.com

Ахлах аудитор: Ш.Мөнхцэцэг
Утас: 99799039 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.15 № 246
танай _____-ны № _____-т

ХӨГЖИЛ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗАР
ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.ТҮВШИНЖАРГАЛ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөгжил хөрөнгө оруулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөгжил хөрөнгө оруулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн үлдэгдлийн 1,375.8 сая төгрөгийн тулган баталгаажуулалт хийгээгүй зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 20 дугаар зүйлийн 20.2.6, Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн 2 "Санхүүгийн тайланд тусгасан бүх тооцоолол үнэн зөв", 5 "Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр бодит үнээр үнэлэгдсэн" -д заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрх бүхий байгууллагын шийдвэрээр 110.1 сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 20.8 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 89.3 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хуучин барилгыг газрын хамт шилжүүлэн бүртгэсэн байна.



Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул

016020346

бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,345,078.2	1,490,778.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,377,815.1	3,418,257.8
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,722,893.3	4,909,035.9
	Өр төлбөрийн нийт дүн	1,000,480.3	945,516.9
	Эзэмшигчдийн өмчийн дүн	3,722,413.0	3,963,519.0
	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	4,722,893.3	4,909,035.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Борлуулалтын орлогын дүн	1,028,998.0	8,674,855.8
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөгийн дүн	341,676.8	187,382.8
	Нийт ашиг алдагдал	687,321.2	8,487,473.0
	Бусад орлого	1,012,899.0	132,926.3
	Ерөнхий ба удирдлагын зардал	1,140,783.5	8,250,354.2
	Бусад зардал	9,104.8	75,137.9
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	551,895.8	272,090.8
	Орлогын татварын зардал	55,189.6	27,428.5
	Татварын дараах ашиг (алдагдал)	496,706.3	244,662.4
	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	496,706.3	244,662.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,729,000.4	3,722,413.0
	Тайлант оны үр дүн	496,706.3	241,106.1
	Эцсийн үлдэгдэл	3,225,706.7	3,963,519.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	5,716,109.8	9,629,126.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	5,081,325.2	9,393,750.6
	Үйл ажиллагааны ЦМГ	634,784.6	235,375.7
	Мөнгөн зарлагын дүн	31,640.5	136,575.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(31,640.5)	(136,575.1)
	Мөнгөн зарлагын дүн	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	603,144.1	98,800.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	627,168.3	1,230,312.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,230,312.4	1,329,113.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт орлого	2,236,256.8	8,807,782.1
	Нийт зардал	1,627,261.0	-
	Нийт ашиг, алдагдал	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 377.6 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 370.1 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 7.5 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийж, баталгаажуулав. Үүнд:

1. Албан хаагчдад олгосон 4.0 сая төгрөгийн зээлийг хандав тусламж, тэтгэмжийн зардалд тайлагнасан.
2. Тайлант оны орлогын ажил гүйлгээнээс 26.9 сая төгрөгийн борлуулалтын НӨАТ-ыг салгаж бүртгээгүй.
3. Данс хооронд шилжүүлсэн 234.4 сая төгрөгийг бусад зардлаар тайлагнаж, зардлыг илүү нэмэгдүүлсэн.
4. Байгууллагын 7 албан хаагчийн 5.1 сая төгрөгийн цалин хөлсийг нийгмийн даатгалын тайланд дутуу тайлагнасан.
5. Хувь хүний орлогын албан татварын ТТ-11 тайланд 27.0 сая төгрөгийн цалин хөлс дутуу тайлагнасан.
6. Төсөл хөтөлбөртэй холбоотой 69.4 сая, даатгалын 0.8 сая, засварын 2.4 сая төгрөгийн зардлыг бусад зардлаар тайлагнасан.

Аудитаар нийт 1,465.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,421.5 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 43.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Төлбөрийн акт

Албан хаагчдад үр дүнгийн шагналыг олгохдоо 0.3 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг дутуу тооцсон зөрчилд төлбөрийн акт хүргүүлэв.

Албан шаардлага

1. Иргэн Ууганбаатарт Ханхонгор булаг хашаажуулах гэрээний төлбөр 10.1 сая төгрөгийг олгосон боловч и-баримтаар баталгаажаагүй байна.
2. Тайланд хугацаанд нийт 6 албан хаагчийн нийгмийн асуудлыг дэмжих, ар гэрийн гачигдлаар нийт 23.0 сая төгрөгийн зээлийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр зээлийн гэрээ байгуулж олгосон байх бөгөөд 2022 онд төлөгдөх ёстой 12.0 сая төгрөгийн төлөлтийг тайланд онд төлүүлж авлагыг барагдуулж ажиллаагүй байна.
3. Санхүүгийн тайлангийн үлдэгдлийн тулган баталгаажуулалтыг анхан шатны баримтаас хөөн шалгаж үзэхэд нийт 1,375.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
4. Санхүүгийн тайлангийн Татварын өр төлбөр дансны үлдэгдэл нийт 127.8 сая төгрөг байгаа нь байх ёстой үлдэгдлээс 23.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан зэрэг зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

1. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас суутган тооцож тайлагнаагүй, ибаримт шивэгдээгүй 7.5 сая төгрөгийн зардал тайлагнасан.
2. Хувь хүмүүсээс авах авлага дансанд сургалтын төлбөрийн зээлтэй холбоотой 22 иргэний 43.9 сая төгрөгийн удаашралттай авлага байна.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТШЗ												
ОНӨААТҮГ	7	377.6	2	32.1			6	370.1			1	7.5
Дүн	7	377.6	2	32.1			6	370.1			1	7.5

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
ТШЗ												
ОНӨААТҮГ	7	1,465.7	1	0.3	4	1,421.5	1	43.9				
Дүн	7	1,465.7	1	0.3	4	1,421.5	1	43.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТШЗ								
ОНӨААТҮГ	1	359.5			1	359.5		
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТШЗ								
ОНӨААТҮГ								
Дүн								
Нийт дүн	1	359.5			1	359.5		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨААТҮГ						1		
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ						1		